

**2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Агаар-12 фонтоор бичиж, 2023 оны 03 дугаар сарын 08-ны “Лхагва” гарагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
“УЛААНБААТАР ХОТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМ” ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
1.	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн “Улаанбаатар хотын эдийн засгийн форум”-ыг зохион байгуулахад бэлтгэл ажлыг хангах хүрээнд дүүрэгт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой мэдээ, мэдээллийн талаар тодруулах.	ЗДО Б.Болормаа
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
2.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/81 дүгээр захирамжийн дагуу Гамшгаас хамгаалах команд штабын дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэгийг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, ажилтан, алба хаагчдын оролцоог хангаж, хуваарийн дагуу өндөр түвшинд зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ОБХ
3.	Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын орчин тойрны өнгө үзэмжийг сэргээх ажлыг эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, ХХҮХ
4.	Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлж, үерийн хамгаалалтын далан сувгийн цас, мөс, лаг шаврыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	ОБХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
5.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, цахим хуудас мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлаа эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ААНБ-ууд
6.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/47 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх.	СТСХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
7.	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, цэвэрлэгээг тогтмолжуулж ажиллах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ААНБ
8.	ААНБ болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтын горимыг тохируулах, хэрэгцээт үед асаахад анхаарах	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
9.	ERP систем шинэчлэгдэж байгаатай холбогдуулан холбогдох байгууллагаас тодруулж, мэдээллийг	ТЗУХ

	ААНБ-уудад хүргүүлж ажиллах.	
10.	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах	ТЗУХ